

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2026/032/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2026 оны 02 дүгээр сарын 13</p> <p>2026</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Даваадорж</p> <p>Утас: 90119422 Цахим хаяг: Davaadorjd@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Албан шаардлага	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЦОХШГ	Цаг, уур, орчны шинжилгээний газар
УЦУОШТ	Ус, цаг, уур, орчны шинжилгээний төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМГИЙН УС, ЦАГ,
УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА Ч.ОЮУНЧИМЭГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд Улсын санхүүжилтээс 3,511,717 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1,622.3 мянга, нийт 3,513,339.9 мянган төгрөгийн төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,512,084.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 40 төрлийн 129,827м² газар бүртгэлтэй байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 13 газрын 46158м² газрыг байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 88.7 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.00	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	429,903,545.4	461,252,500.2
31.00	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,000.0	-
312.00	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,000.0	-
3,121.00	Төгрөг	20,000.0	-
31,211.00	Төрийн сангийн харилцах	20,000.0	-
33.00	АВЛАГА	411,807.3	2,776,892.4
33,100.00	Ажиллагчидтай холбогдсон авлага	411,807.3	64,250.0
335.00	Бусад авлага	-	2,712,642.4
3,351.00	Байгууллагаас авах авлага	-	2,712,642.4
35.00	БАРАА МАТЕРИАЛ	429,471,738.2	458,475,607.8
351.00	Түүхий эд материал	379,326,368.2	389,156,916.6
35,110.00	Тусгай зориулалттай материал	379,326,368.2	389,156,916.6
354.00	Хангамжийн материал	50,145,370.0	69,318,691.2
35,410.00	Бичиг хэргийн материал	906,336.4	906,336.4
35,420.00	Аж ахуйн материал	46,417,904.1	63,010,225.3
35,440.00	Түлш, шатах тослох материал	240,000.0	2,821,000.0
35,470.00	Бусад хангамжийн материал	2,581,129.5	2,581,129.5
2.00	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,271,334,871.2	1,461,496,224.6
39.00	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,271,334,871.2	1,461,496,224.6
392.00	Биет хөрөнгө	1,043,684,537.8	1,234,191,724.5
39,201.00	Барилга, байгууламж, орон сууц	676,861,103.7	676,861,103.7
39,202.00	Хуримтлагдсан элэгдэл	(77,508,820.4)	(91,318,092.6)
39,203.00	Авто-тээврийн хэрэгсэл	84,588,723.8	275,709,367.2
39,204.00	Хуримтлагдсан элэгдэл	(56,690,583.0)	(78,013,865.5)
39,205.00	Машин тоног төхөөрөмж (компьютер)	610,642,116.6	719,151,216.6
39,206.00	Хуримтлагдсан элэгдэл	(198,113,441.6)	(272,070,676.0)
39,207.00	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,567,750.0	18,799,750.0
39,208.00	Хуримтлагдсан элэгдэл	(13,662,311.3)	(14,927,078.9)
39,214.00	Бусад үндсэн хөрөнгө	6,280,000.0	6,280,000.0

**Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан**

39,215.00	Хуримтлагдсан элэгдэл	(6,280,000.0)	(6,280,000.0)
393.00	Биет бус хөрөнгө	227,650,333.4	227,304,500.2
39,301.00	Програм хангамж	3,046,219.0	3,046,219.0
39,302.00	Хуримтлагдсан элэгдэл	(1,537,885.6)	(1,883,718.8)
39,303.00	Бусад биет бус хөрөнгө	226,142,000.0	226,142,000.0
3.00	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,701,238,416.7	1,922,748,724.8
4.00	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,766,621.8	11,464,375.0
41.00	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,766,621.8	11,464,375.0
413.00	Өглөг	9,766,621.8	11,464,375.0
41,310.00	Ажилчидтай холбогдсон өглөг	9,766,621.8	1,028,746.8
41,320.00	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,618,928.3
4,136.00	Бусад өглөг	-	5,816,700.0
41,361.00	Байгууллагад төлөх өглөг	-	5,436,700.0
41,362.00	Хувь хүмүүст төлөх өглөг	-	380,000.0
5.00	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,691,471,794.9	1,911,284,349.8
51.00	Засгийн газрын хувь оролцоо	1,691,471,794.9	1,911,284,349.8
511.00	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	587,740,743.9	587,740,743.9
51,101.00	Өмч: - төрийн	587,740,743.9	587,740,743.9
512.00	Хуримтлагдсан үр дүн	774,861,468.2	994,674,023.0
51,210.00	Өмнөх үеийн үр дүн	419,395,871.8	774,861,468.2
51,220.00	Тайлант үеийн үр дүн	355,465,596.4	219,812,554.9
51,300.00	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	328,869,582.9	328,869,582.9
6.00	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,701,238,416.7	1,922,748,724.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,564,675,573.1	3,896,335,819.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	299,113,097.1	347,739,961.5
120	Нийтлэг татварын бус орлого	299,113,097.1	347,739,961.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	299,113,097.1	347,739,961.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.0	1,210,450.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	298,913,097.1	346,529,511.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,265,562,476.0	3,548,595,858.0

**Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан**

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,198,753,100.0	3,511,717,648.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,198,753,100.0	3,511,717,648.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,809,376.0	36,878,210.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,292,376.0	36,878,210.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,517,000.0	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,209,108,625.7	3,676,523,264.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,209,108,625.7	3,676,523,264.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,137,185,121.8	3,465,770,916.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,606,360,402.3	2,889,453,370.5
210101	Үндсэн цалин	1,555,590,712.2	1,558,690,424.3
210102	Нэмэгдэл	779,195,740.2	910,855,846.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	194,029,000.0	198,855,800.0
210104	Урамшуулал	77,544,950.0	221,051,300.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	349,454,400.5	366,161,200.6
210201	Тэтгэврийн даатгал	234,046,556.0	244,710,462.3
210202	Тэтгэмжийн даатгал	26,439,652.9	28,911,827.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	25,995,094.2	22,353,685.8
210204	Ажилгүйдлийн даатгал	12,594,619.8	14,037,145.4
210205	Эрүүл мэндийн даатгал	50,378,477.5	56,148,079.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,899,668.0	51,166,502.7
210301	Гэрэл, цахилгаан	7,602,328.0	9,536,142.7
210302	Түлш, халаалт	44,556,340.0	41,250,360.0
210303	Цэвэр, бохир ус	741,000.0	380,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	40,490,411.9	37,198,008.9
210401	Бичиг хэрэг	1,663,000.0	3,623,832.0
210402	Тээвэр, шатахуун	10,425,900.0	7,357,439.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,224,958.4	5,463,245.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,700,538.0	14,675,092.0
210408	Бараа материал ақталсны зардал	5,476,015.5	6,078,400.4
2105	Нормативт зардал	-	1,530,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,530,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	220,000.0	3,145,200.0

**Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан**

210601	Багаж, техник, хэрэгсэл	220,000.0	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,654,200.0
210604	Урсгал засвар		1,491,000.0
2107	Томилолт, зочны зардал	3,144,000.0	2,271,200.0
210702	Дотоод албан томилолт	3,144,000.0	2,271,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,266,296.4	3,980,070.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,151,986.0	1,526,900.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		248,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	277,500.0	399,092.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	305,335.4	217,200.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.0	110,252.0
210807	Газрын төлбөр	1,521,475.0	1,478,626.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,349,942.7	110,865,364.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	217,700.0	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		165,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,132,242.7	110,700,364.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,923,503.9	210,752,348.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,924,017.0	210,670,824.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,200,000.0	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,724,017.0	210,670,824.2
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	999,486.9	81,523.8
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	999,486.9	81,523.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	355,566,947.4	219,812,554.9
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	355,566,947.4	219,812,554.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,265,762,476.0	3,550,218,115.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,000.0	1,622,257.3
120	Нийтлэг татварын бус орлого	200,000.0	1,622,257.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,000.0	1,210,450.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.0	1,210,450.0

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

120009	Бусад орлого	-	411,807.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,265,562,476.0	3,548,595,858.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,198,753,100.0	3,511,717,648.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,198,753,100.0	3,511,717,648.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,809,376.0	36,878,210.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,292,376.0	36,878,210.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,517,000.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,118,471,015.0	3,549,538,215.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,118,471,015.0	3,549,538,215.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,046,547,511.1	3,337,592,458.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,618,908,788.3	2,901,978,829.4
210101	Үндсэн цалин	1,371,479,389.5	1,408,256,300.0
210102	Нэмэгдэл	766,852,899.0	974,349,588.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	312,875,749.8	262,843,621.3
210104	Урамшуулал	167,700,750.0	256,529,319.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	327,551,200.0	363,957,100.0
210201	Тэтгэврийн даатгал	222,794,800.0	247,490,900.0
210202	Тэтгэмжийн даатгал	26,189,100.0	29,116,700.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,094,500.0	14,558,200.0
210204	Ажилгүйдлийн даатгал	13,094,600.0	14,558,200.0
210205	Эрүүл мэндийн даатгал	52,378,200.0	58,233,100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,589,668.0	53,561,059.9
210301	Гэрэл, цахилгаан	7,602,328.0	9,069,699.9
210302	Түлш, халаалт	37,246,340.0	43,831,320.0
210303	Цэвэр, бохир ус	741,000.0	660,040.0
2104	Хангамж, бараа материалын зардал	10,997,858.4	7,029,299.0
210401	Бичиг хэрэг	589,000.0	-
210402	Тээвэр, шатахуун	4,971,900.0	2,489,100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,224,958.4	3,655,199.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	212,000.0	885,000.0
2105	Нормативт зардал	187,700.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	187,700.0	-

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,620,000.0	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	220,000.0	-
210604	Урсгал засвар	8,400,000.0	-
2107	Томилолт, зочны зардал	3,144,000.0	2,271,200.0
210702	Дотоод албан томилолт	3,144,000.0	2,271,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,548,296.4	7,994,970.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,433,986.0	5,541,800.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	248,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	277,500.0	429,092.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	305,335.4	187,200.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.0	110,252.0
210807	Газрын төлбөр	1,521,475.0	1,478,626.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	800,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	800,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,923,503.9	211,945,757.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,924,017.0	210,670,824.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,200,000.0	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,724,017.0	210,670,824.2
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	999,486.9	1,274,932.8
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	999,486.9	1,274,932.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	147,291,461.0	679,900.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	147,190,110.0	699,900.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	147,190,110.0	699,900.0
2200	Дотоод эх үүсвэрээр	147,190,110.0	699,900.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	147,190,110.0	699,900.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(147,190,110.0)	(699,900.0)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	101,351.0	(20,000.0)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,000.0	20,000.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,000.0	-

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.9	328,869,582.9	419,395,871.8		1,336,006,198.6
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0		0.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	587,740,743.9	328,869,582.9	419,395,871.8	0.0	1,336,006,198.6
C07	Тайлант үеийн үр дүн			355,465,596.4		355,465,596.4
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.9	328,869,582.9	774,861,468.2	0.0	1,691,471,794.9
D01	2025 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.9	328,869,582.9	1,130,327,064.5	0.0	1,691,471,794.9
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0		0.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	587,740,743.9	328,869,582.9	774,861,468.2	0.0	1,691,471,794.9
D08	Тайлант үеийн үр дүн			219,812,554.9		219,812,554.9
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.9	328,869,582.9	994,674,023.0	0.0	1,911,284,349.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,516,062,610.0	3,512,084,972.5	3,977,637.5	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,478,984,400.0	3,510,462,715.2	(31,478,315.2)	100.9
Улсын төсвөөс санхүүжих	3,478,984,400.0	3,510,462,715.2	(31,478,315.2)	100.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,000.0	1,622,257.3	(1,422,257.3)	811.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.0	1,622,257.3	(1,422,257.3)	811.1
Ажиллагчидтай холбогдсон зардал	3,232,557,800.0	3,232,557,719.4	80.6	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,868,600,700.0	2,868,600,619.4	80.6	100.0
Үндсэн цалин	1,408,256,300.0	1,408,256,300.0	-	100.0
Нэмэгдэл	939,240,200.0	940,971,378.6	(1,731,178.6)	100.2
Унаа хоолны хөнгөлөлт	264,574,800.0	262,843,621.3	1,731,178.7	99.3
Урамшуулал	256,529,400.0	256,529,319.6	80.4	100.0

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	363,957,100.0	363,957,100.0	-	100.0
Тэтгэврийн даатгал	247,490,900.0	247,490,900.0	-	100.0
Тэтгэмжийн даатгал	29,116,700.0	29,116,700.0	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	14,558,200.0	14,558,200.0	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	14,558,200.0	14,558,200.0	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	58,233,100.0	58,233,100.0	-	100.0
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	74,089,000.0	68,856,428.9	5,232,571.1	92.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,579,900.0	53,561,059.9	18,840.1	100.0
Гэрэл, цахилгаан	9,069,700.0	9,069,699.9	0.1	100.0
Түлш, халаалт	43,845,600.0	43,831,320.0	14,280.0	100.0
Цэвэр, бохир ус	664,600.0	660,040.0	4,560.0	99.3
Хангамж, бараа материалын зардал	7,705,600.0	7,029,299.0	676,301.0	91.2
Тээвэр, шатахуун	2,489,100.0	2,489,100.0	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,655,200.0	3,655,199.0	1.0	100.0
Бичиг хэрэг	79,700.0		79,700.0	-
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	581,700.0		581,700.0	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	899,900.0	885,000.0	14,900.0	98.3
Нормативт зардал	1,523,000.0	-	1,523,000.0	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,523,000.0		1,523,000.0	-
Эд хогшил, урсгал засварын зардал	2,346,500.0	699,900.0	1,646,600.0	29.8
Багаж, техник, хэрэгсэл	699,900.0	699,900.0	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,646,600.0		1,646,600.0	-
Томилолт, зочны зардал	2,342,000.0	2,271,200.0	70,800.0	97.0
Дотоод албан томилолт	2,342,000.0	2,271,200.0	70,800.0	97.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,792,000.0	4,494,970.0	1,297,030.0	77.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,042,000.0	2,041,800.0	200.0	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	248,200.0	248,000.0	200.0	99.9
Даатгалын үйлчилгээ	1,614,600.0	429,092.0	1,185,508.0	26.6
Тээврийн хэрэгслийн татвар	187,200.0	187,200.0	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	118,800.0	110,252.0	8,548.0	92.8

**Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан**

Газрын төлбөр	1,581,200.0	1,478,626.0	102,574.0	93.5
Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.0	800,000.0	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.0	800,000.0	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	241,407,600.0	210,670,824.2	30,736,775.8	87.3
Бусад урсгал шилжүүлэг	241,407,600.0	210,670,824.2	30,736,775.8	87.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	210,909,600.0	210,670,824.2	238,775.8	99.9
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,548,054,400.0	3,512,084,972.5	35,969,427.5	99.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	20,000.00		0.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		0.0%
АЖИЛЛАГСАДЫН ТОО	102.00	88.00	14.0	86.3
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	94	80	14.0	85.1
Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
Гэрээт ажилтан	3	3	-	100.0

/2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,878,210.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,878,210.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,878,210.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,378,210.0
210102	Нэмэгдэл	33,378,210.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,500,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,878,210.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,878,210.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,878,210.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь уур амьсгалын өөрчлөлт, орчны бохирдол, усны нөөцийн төлөв байдлыг тасралтгүй ажиглаж, цаг агаарын урьдчилсан мэдээ боловсруулан иргэд, аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр

хангах үүрэгтэй. Тус төв нь шинжлэх ухаан, техник технологийн дэвшилд тулгуурлан үйл ажиллагаагаа сайжруулж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх мэдээ боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Тайлант онд ЦУОШГ-ын даргын 2025 оны А/162 дугаар тушаалаар батлагдсан бүтэц орон тооны хязгаарыг баримтлан Баянхонгор аймгийн УЦУОШТ-ийн даргын 2025 оны А/02, А/21 дугаар тушаалуудаар орон тоог баталж 88 оронтойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төрийн бодлого зохицуулалтын газраас 2025 онд “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт”-ийг шалгасан байна. Тус шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан байгууллагуудад газартай холбоотой газар эзэмших, ашиглах эрхийн зөрчлийг арилгах, цаашид (www.gazar.gov.mn)-д бүртгэгдээгүй буюу Э-дугаар авч байгууллага дээр бүртгэлгүй газрын зөрчлийг арилгах үүргийг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэх үүрэг өгсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь УЦУОШГ-ын баталсан “нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төв нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 221,510.3 мянган төгрөг буюу 13,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20.0	-	(20.0)
Авлага	411.8	2,776.9	2,365.1
Бараа материал	429,471.7	458,475.6	29,003.9
Үндсэн хөрөнгө	1,271,334.9	1,461,496.2	190,161.4
Хуримтлагдсан элэгдэл	(353,793.0)	(464,493.4)	(110,700.4)
Нийт хөрөнгө	1,701,238.4	1,922,748.7	221,510.3
Өр төлбөр	9,766.6	11,464.4	1,697.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,691,471.8	1,911,284.3	219,812.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,701,238.4	1,922,748.7	221,510.3

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн данс 0 үлдэгдэлтэй болж 20.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эцэст 2,776.9 мянган төгрөгт болж, өмнөх үеэс 2,365.1 мянган төгрөгөөр өссөн байна. Авлагын өсөлтөд голлон нөлөөлсөн зүйл нь ХХОАТ-ын өглөгийг тайлант оны эцэст НД-д шимтгэлийн гүйлгээтэй зөрүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл тайлант оны эцэст 458,475.6 мянган төгрөг болж, өмнөх үеэс 29,003.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн хөрөнгөөр 58,408.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 28,812.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 69,694.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 6,078.4 мянган төгрөгийн материал акталж устгасан байна.

Бараа материалын өсөлтөд “борооны пуужин” данс 21,375.8 мянган төгрөг ба 2025 онд Баянхонгор аймагт бороо, хур тунадас ихтэй байсантай холбоотойгоор борооны пуужингийн зарцуулалт бага байсан нь үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,461,496.2 мянган төгрөг болж 190,161.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд МУ-ын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/325 тушаалаар 176,527.1 мянган төгрөгийн үнэлгээтэй Nissan Y61 загварын авто машин, А/729 тушаалаар 11,593.5 мянган төгрөгийн 3ш мотоцикл, Цаг, уур, орчны шинжилгээний газраас хуваарилсан 105,341.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлж авсан нь үндсэн хөрөнгө өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 11,464.4 мянган төгрөг болж өмнөх оноос 1,967.8 төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд ХХОАТ-ын өглөг шилжүүлэхдээ НДШ-ийн шимтгэлийн гүйлгээтэй зөрүүлэн хийсэн, ЦУОШГ-аас төсвийн эрх 12 сар дээр нээж өгөөгүйгээс өр төлбөр өсөхөд нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,911,284.3 мянган төгрөг болж 219,812.6 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үр дүн 219,812.6) мянган төгрөгтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,963,506.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,963,506.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 316,088.0 мянган төгрөгөөр бууруулж 3,647,418.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд оны эхэнд батлагдсан төсөвт 3 удаа тодотгол хийж төсвийн хуваарийг шинэчлэн ирүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төв нь улсын төсвийн санхүүжилт 3,511,717. мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1,622.3 мянга, нийт 3,513,339.9 мянган төгрөгийн төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,512,084.9 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 1,254.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,512,084.9 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байна. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,297.0 мянга, мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80801 Үндсэн үйл ажиллагаа	3,304,604.8	3,299,310.9	5,293.9	99.8%
2	80220 Холбооны суваг ашиглалтын хөлс	1,800.0	1,799.9	0.1	99.9%
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	241,407.6	210,732.2	30,675.4	87.4%
4	81859 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	242.0	242.0	0	100%
	Нийт дүн	3,548,054.4	3,512,084.9	35,969.4	98.9%

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

Бүтэц, орон тооны хязгаарыг ЦУОШГ-ын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/162 дугаар тушаалаар шинэчлэн тогтоож, байгууллагын орон тоог 85 байхаар баталсан байна.

Харин Баянхонгор аймгийн УЦОШТ-ийн төвийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/01 дугаар тушаалаар 102 орон тоо батлагдсан бөгөөд 2025 онд 5 орон тоог цомхотгол хийсэн байна. Үүнд: хэлтсийн дарга 2, өлзийт сумын тундасын харуул 1, Гурванбулаг сумын станцтын техникч 2. Гурванбулаг суманд 5 орон тоотой байснаас 2-ыг хассан байна.

Оны эцсээр 88 орон тооны ажилтан ажилласан ба . Гэрээт 3 ажилтныг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл ажиллуулах хугацаа заан ажиллуулсан байна.

Тус байгууллага нь хоолны хөнгөлөлт нэг өдөрт аймгийн төв 15.0 мянга, хөдөө суманд 5.0 мянган төгрөгөөр тооцож 264,574.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 262,843.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд тус байгууллага нь “Ординат ХХК”-ны санхүүгийн тайлангийн Unicus программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн ашигладаггүй 3 программ бүртгэлтэй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар УТ байгууллагуудын албан хаагчдын ОН нэмэгдэл хөлс, аймгийн Засаг даргын А/137 дугаар захирамжаар цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх зориулалтаар нийт 36,878.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орж ирж урсгал үйл ажиллагаанд 36,878.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төв нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Ус,цаг, уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баянхонгор аймгийн Ус,цаг, уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Ус,цаг, уур, орчны шинжилгээний төвийн дарга Ч.Оюунчимэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Энхжаргал нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлын 3,479,200.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 34,800.0 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 22,600.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж батлагдсан төсвийн 99.0 хувийг зарцуулж 35,969.9 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 224,926.8 мянган төгрөгийн 9 гүйлгээ, орлогын 3,523,172.2 мянган төгрөгийн 19 гүйлгээ мэдээлэхээс 16,692.6 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээг мэдээлээгүй байсан ба аудитын явцад нөхөж мэдээлүүлсэн. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 19 шийдвэрийг тус тус бүрэн байршуулж мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг “Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар”-ын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, нийт 9,388,241.2 мянган төгрөгийн дүнтэй зөрчил илрүүлсэн байна

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	9,388,241.2	1	9,388,241.2	100
Нийт дүн	1	9,388,241.2	1	9,388,241.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2024 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/З дугаар тушаалын хавсралтаар батлагдсан загварын дагуу бэлтгэн гаргаагүй байна. Иймд дараагийн аудитаар онцгойлон анхаарч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 966.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд зөрчлийг арилгах 966.2 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 966.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын хэмжээнээс 21,633.8 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 40 төрлийн 129,827м² газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazag.gov.mn)-тэй тулган шалгахад 13 газрын 46158м² газрыг байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: Аймгийн ГХБХБГ-тай тооцоо нийлж газрын хэмжээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах албан шаардлагыг хүргүүлэв.

5.1.2 Байгууллагын хүний нөөцийн ажилтан " хүний нөөцийн удирдлага мэдээллийн систем"-д бүртгэхдээ ажилтнуудын ажил мэргэжлийн кодыг буруу оруулсан байна. Үүний улмаас Нийгмийн даатгалын шимтгэлийн (НДШ) тайлан илгээх үед тухайн ажилтны ажил мэргэжлийн код НДС–ийн системд бүртгэлтэй мэдээлэлтэй зөрж сар бүр НДС–ийн тооцоололд зөрүү үүссэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32.2.2."орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэсэн заалттай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилган, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баянхонгор аймгийн Ус, цаг, уур, орчны шинжилгээний төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 40 төрлийн 129,827м2 газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 13 газрын 46158м2 газрыг байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэж орлого аваагүй байна	1	0			1	-		
Байгууллагын хүний нөөцийн ажилтан " хүний нөөцийн удирдлага мэдээллийн систем"-д бүртгэхдээ ажилтнуудын ажил мэргэжлийн кодыг буруу оруулсан байна. Үүний улмаас Нийгмийн даатгалын шимтгэлийн (НДШ) тайлан илгээх үед тухайн ажилтны ажил мэргэжлийн код НДС-ийн системд бүртгэлтэй мэдээлэлтэй зөрж сар бүр НДС-ийн тооцоололд зөрүү үүссэн байна.	1	966.2			1	966.2		
Нийт дүн	2	966.2			2	966.2		

-----oO-----